**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

---

2018 оны 09 дугаар сарын 25-ны өдөр — Дугаар А/384, А/548 — Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ/ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Булган аймгийн Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс"-ийг 1 дүгээр, уг бүсэд мөрдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус батлалсугай.

2. Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоосон талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлэхийг Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус даалгасугай.

3. Энэхүү хамтарсан тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Булган сумын агаарын бохирдлыг бууруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Ц.Бат-Өлзий/ нарт тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ